

“ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХАМТДАА” АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

2018.06.13

- ХХҮГазрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн 2018 оны ажлын төлөвлөгөөг гаргаж батлуулсан байна.
- Сар шинийн баярыг тохиолдуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын албан хаагчид хуваарь гарган хариуцлагатай жижүүрийн ажлыг хийсэн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан 2018 онд хэрэгжих төсөл хөтөлбөрийн сургалтыг Сум, баг хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн, Сум багийн хөгжлийн нийгмийн ажилтнуудад зориулан зохион байгуулсан байна.
- Байгууллагын удирдлага, нийт албан хаагчдад бүх нийтээр дагаж мөрдөхөөр батлагдсан зарим хуулийн холбогдох сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлөөс аймгийн Цагдаагийн газартай хамтран “Эрүүгийн тухай хууль” холбогдох дүрэм, журмын талаар Захиргаа хяналтын хэлтсээс аймгийн Анхан шатны шүүхийн газартай хамтран “Авлигын эсрэг хууль”, “Зөрчлийн тухай хууль”-ийн талаар тус тус сургалтуудыг авлаа.



- Байгууллагын нийт албан хаагчдад бүх нийтээр дагаж мөрдөхөөр батлагдсан зарим хуулийн холбогдох сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Захиргаа хяналтын хэлтсээс авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Авлигын эсрэг хууль” бусад эрсдлийн талаар сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгууллаа.



- Аймгийн Прокурортой хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийгээ хэрхэн хамгаалах, эрсдэлтэй нөхцөл байдалд ямар арга хэмжээ авах талаар 2018 оны 05 дугаар сарын 17-ны 16 цагт сургалт зохион байгууллаа.



- 3. Аймгийн Тагнуулын байгууллагатай хамтран 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдөр төрийн болон байгууллагын нууцын тухай хуулиар сургалт зохион байгууллаа.



- Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, хамалжийн үйлчилгээний газраас 05 сарын 15-аас 24-ний өдрүүдэд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлэх үйлчилгээгээ иргэдэд ойртуулах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулсан байна.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ТХХМэргэжилтэн
ХЯНАСАН: Захиргаа Хэлтсийн Дарга

/Б.Мөнхцэцэг/

/Б.Цэвээндорж/